



**МОНГОЛ УЛСЫН
ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2025 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/142

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.4 дахь заалт, Зам, тээврийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн "Далайн захиргааны 2025 оны орлого, зарлагын төлөвлөгөө батлах тухай" А/14 дүгээр тушаал, Монгол Улсын Далайн захиргааны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагад ажиллаж буй ажилтан, залуучуудад эх оронч үзэл, төрт ёсны мэдлэг, боловсролыг дэлгэрүүлэх зорилгоор зорилтот аяныг 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. Аян зохин байгуулах ажлын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, холбогдон гарах зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 2,856,500 (хоёр сая найман зуун тавин зургаан мянга таван зуу) төгрөгийн зардлыг холбогдох зардлаас зохих журмын дагуу санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (М.Гантулга)-д зөвшөөрсүгэй.

4. Аян зохион байгуулсан тайланг ажлын 5 хоногт багтаан удирдлагад танилцуулахыг Дотоод үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн (Д.Энхмандах)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.САЙНБАЯР

00000433

АЯНЫ УДИРДАМЖ

Нэг.Зорилго

Байгууллагад ажиллаж буй ажилтан, залуучуудад эх оронч үзэл, төрт ёсны мэдлэг, боловсролыг дэлгэрүүлэх зорилготой.

Хоёр.Хугацаа

Аяныг 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 31-нийг хүртэл хугацаанд зохион байгуулагдана.

Гурав.Хамрах хүрээ

Байгууллагын нийт ажилтнууд.

Дөрөв.Санхүүжүүлэх эх үүсвэр

Монгол Улсын Далайн захиргааны 2025 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгагдсан төсөв зардлаас.

Тав.Хэрэгжүүлэх арга хэмжээ

➤ 1 дэх долоо хоног (10/07–10/10)

Чингис хаан үндэсний музей үзэж, Монголын түүх, угсаатны соёл, үндэсний бахархлын үнэт өвтэй танилцах.

➤ 2 дахь долоо хоног (10/13–10/17)

Монгол Улсын Төрийн ордонтой танилцаж, төрийн байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн зохион байгуулалт болон түүхэн хөгжилтэй танилцах.

➤ 3 дахь долоо хоног (10/20–10/24)

Монгол банкны “Эрдэнэсийн сан” болон “Мөнгөн тэмдэгтийн танхим”-тай танилцаж, үндэсний валютын түүх, үнэт металлын нөөц, мөнгө санхүүгийн бодлогын ач холбогдлыг судлах.

➤ 4 дэх долоо хоног (10/27–10/31)

- Хэлтэс, албадын сүүлийн үед хийгдэж буй ажил;
- Сургалтын туршлага (World Maritime University (WMU)).

Зургаа.Ажлын үр дүнг тайлагнах

Аяны хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нэгтгэн боловсруулж, аяныг дуусгаснаас хойш ажлын 5 хоногийн дотор байгууллагын удирдлагад танилцуулна.

Монгол Улсын Далайн захиргааны даргын
2025 оны 10 дугаар сарын 2 -ний өдрийн
А/142 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт

ЗАРДЛЫН ТӨСӨВ
/2025.10.07-2025.10.31-ний өдрүүдэд/

		/төгрөгөөр/
№	Зардлын нэр	Төсөв
1.	Чингис хаан үндэсний музей	
	37 ажилтан *45,000төгрөг Тайлбарлагч 1*100,000төгрөг Өглөөний цай 37ажилтан*24,500төгрөг	2,671,500
2.	Монгол банкны эрдсийн сан, мөнгөн тэмдэгтийн танхимтай танилцах	
	37 ажилтан*5000төгрөг	185,000
	Нийт дүн:	2,856,500

---oOo---

АЯН ЗОХИОН БАЙГУУЛСАН ТУХАЙ ИЛТГЭХ ХУУДАС

Нэг. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсын Далайн захиргаанаас ажилтан, албан хаагчдын эх оронч үзэл, төрт ёсны уламжлал, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Эх оронч үзэл, төрт ёсны мэдлэг, боловсролыг дэлгэрүүлэх” аяныг 2025 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 07-ны хооронд нийт ажилтнуудыг хамруулан зохион байгуулав.

Аяны хүрээнд Монгол Улсын түүх, соёл, төрийн байгууллагын тогтолцоо, мөнгө, санхүүгийн систем, түүх, хөгжлийн талаар танилцах, туршлага хуваалцах уулзалт зэрэг олон талт арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлсэн.

Хоёр. Зорилго

Аяны зорилго нь байгууллагын ажилтан, албан хаагчдын эх оронч үзлийг бэхжүүлэх, төрийн байгууллагын түүхэн хөгжил, үндэсний үнэт зүйлс, төрт ёсны уламжлалын талаар мэдлэг олгох, төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн.

Гурав. Зардал

Аяныг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг Монгол Улсын Далайн захиргааны 2025 оны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд тусгагдсан төсвийн хүрээнд зарцуулсан болно.

Дөрөв. Хэрэгжүүлсэн арга хэмжээ

1. Нэгдүгээр долоо хоног (10-р сарын 13-17)

Байгууллагын ажилтнууд Чингис хаан Үндэсний музейг үзэж, Монголын түүх, төрт ёсны үүсэл, угсаатны соёл, ахуй амьдрал, урлаг, үнэт өвийн талаар мэдээлэл авч, түүхэн дурсгал, үзмэрүүдтэй танилцсан.

Энэхүү үйл ажиллагаа нь ажилтнуудын үндэсний бахархал, өв соёлоо хадгалан хамгаалах ухамсрыг нэмэгдүүлж, Монгол Улсын төрт ёсны хөгжлийн үе шатыг ойлгоход чухал ач холбогдолтой байв.

2 Хоёрдугаар долоо хоног (10-р сарын 27-31)

Монголбанкны “Эрдэнэсийн сан” болон “Мөнгөн тэмдэгтийн танхим”-тай танилцаж, үндэсний валютын үүсэл хөгжил, мөнгө, санхүүгийн бодлого, үнэт металлын нөөцийн ач холбогдлын талаар ойлголттой болсон.

3. Гуравдугаар долоо хоног (11-р сарын 07-ны өдөр)

Тус уулзалтын үеэр Далайн тээвэр, хуурай боомтын хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Мөнхцэцэг Дэлхийн Далайн Их Сургуульд (World Maritime University, WMU) өөрийн суралцсан туршлага, сургуульд эзэмшсэн мэдлэг, ур чадварын талаар илтгэл танилцуулга хийсэн.

Тус сургуульд боомтын менежмент (Port Management) чиглэлээр суралцсан бөгөөд сургалтын хөтөлбөрийн агуулга, олон улсын тээвэр, боомтын үйл ажиллагааны менежмент, ложистикийн сүлжээ, далайн тээврийн эрх зүй, тогтвортой хөгжлийн зарчмын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Мөн WMU-ийн сургалтын орчин, судалгааны аргачлал, олон улсын профессор багш нарын туршлага, хамтын ажиллагааны онцлогийг хуваалцав.

Мөн Архив, бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн М.Удвалцэцэг Монгол бичгийн өв соёл, түүний өнөөгийн байдал, залуусын дунд монгол бичгийн сонирхлыг сэргээх талаар сонирхолтой

илтгэл тавьсан. Энэхүү илтгэл нь ажилтнуудын соёлын ухамсар, хэл бичгийн сонирхлыг нэмэгдүүлж, үндэсний өвийг хамгаалах сэдэл өгсөн нь чухал ач холбогдолтой байв.

Тав. Дүгнэлт

Ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулсан аян нь байгууллагын ажилтнуудын ёс зүйн ойлголт, хандлагыг сайжруулах, дотоод соёлыг төлөвшүүлэх зорилготойгоор хэрэгжсэн.

Аяны хугацаанд төлөвлөсөн арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, ажилтнуудын оролцоог хангаж ажилласан.

Мөн Дэлхийн Далайн их сургуульд суралцсан тухай туршлага болон Монгол бичгийн өнөөгийн байдал илтгэлүүд нь ажилтнуудын мэдлэгийг өргөжүүлэх, үндэсний үнэт зүйлсийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэхэд чиглэсэн ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Танилцсан:

Дарга



М.Өлзий

Хянасан:

Захиргаа, удирдлагын хэлтсийн
дарга



Т.Мөнхбаяр

Илтгэх хуудас бичсэн:

Дотоод үйл ажиллагаа хариуцсан
мэргэжилтэн



Д.Энхмандах

Монгол Улсын Далайн захиргааны
даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны
өдрийн А/142 дугаар тушаалын Нэгдүгээр хавсралт


АРГА ХЭМЖЭЭНИЙ ФОТО ЗУРАГ



Зураг1. Чингис хаан Үндэсний музей



Зураг 2. Монголбанкны “Эрдэнэсийн сан” болон “Мөнгөн тэмдэгтийн танхим”



Зураг 3.Өглөөний уулзалт, сургалт